



ДУНДГОВЬ АЙМАГ
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 30 өдөр

Дугаар 8/49

Аргатай

Г Хөдөө аж ахуйн салбар болон төв, Г
суурин газрын 2023-2024 оны өвөлжилт,
хаваржилтын бэлтгэл хангах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны "Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай" 279 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/459 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөө аж ахуйн салбар, төв суурин газрын өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангуулах ажлыг зохион байгуулан, хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: Б.Золзаяа (Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: Э.Сувд (ХАА хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Ц.Батбилэг (Мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн)

М.Мөнгөнхуяг (1-р багийн засаг дарга)

Э.Дашдамба (2-р багийн засаг дарга)

Б.Пүрэвбаяр (3-р багийн засаг дарга)

С.Цэрэн-Янжин (Ерөнхий боловсролын сургуулийн захирал)

Б.Цэцэгжаргал (Цэцэрлэгийн эрхлэгч)

Ц.Ариунтуяа (Эрүүл мэндийн төвийн эрхлэгч)

Б.Батчимэг (Соёлын төвийн эрхлэгч)

Д.Оюун-эрдэнэ (Цаг уурын алба)

З.Ганбаяр (Цахилгаан түгээх станц)

482201099


2. Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах нарийвчилсан төлөвлөгөөг гаргаж Сумын засаг даргаар батлуулан хэрэгжүүлж ажиллан ажлын явц дүн мэдээг сар бүр засаг даргын зөвлөлд мэдээлж байхыг ажлын хэсгийн дарга (Б.Золзаяа)-д үүрэг болгосугай.

3. Хадлан тэжээл бэлтгэх бололцоотой аймаг сумдын удирдлагуудтай урьдчилан тохиролцож өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлыг ажлын хэсгийн дарга (Б.Золзаяа)-д, сумын хэмжээний нийт өвөлжих хаваржих малын тоо, өвөл хаврын улиралд отор хийх өрх, хүн ам, малын тоог нарийвчлан гаргаж, бэлчээрийн даац, багтаамж сайтай газруудаар отор нүүдэлд гарах гэрээ хэлэлцээр хийх малчдаар төлөвлөгөөт гар тэжээл бэлтгүүлэх, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх, өвлийн хүндрэл цаг агаарын урьдчилан мэдээллийг малчдад хүргэхийг хөдөө аж ахуйн тасаг, багийн засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Албан байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг ханган хэрэгжүүлэн ажиллахыг байгууллагын дарга эрхлэгч нарт даалгасугай.

4. Төлөвлөгөөт ажлыг үр дүнтэй зохион байгуулж дүн мэдээг цаг хугацаанд нь дээд шатны байгууллагад нь гаргаж өгөхийг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



ЗАСАГ ДАРГЫГ ГҮР

Б.ЗОЛЗАЯА